



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 он 09 сарын 05 өдөр

Дугаар A/369

Мандалговь

Г Ажлын хэсэг томилох тухай Т

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтооюур батлагдсан "Бичил уурхайгаар ашигт малтмал ашиглах журам"-ын 8.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Бичил уурхай эрхлэгчдээс ашигт малтмал худалдан авах аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж байх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Мэнхчулуун(Засаг даргын орлогч)
Гишүүд: Х.Анхбаяр (Байгаль орчин аялал жуулчлалын газрын ахлах мэргэжилтэн)
М.Туяацэцэг (Татварын хэлтсийн дарга)
Р.Цэрэндорж (МХГ-ын Геологи уул уурхайн хяналтын улсын байцаагч)


Нарийн бичгийн дарга: П.Очирбат (ХОХБТХ-ийн мэргэжилтэн)

Хоёр. Бичил уурхайгаас олборлосон ашигт малтмалыг худалдан авах эрх бүхий аж ахуйн нэгжид тавигдах шаардлагыг хавсралтаар баталсугай.

Гурав. Сум тус бурд 4 хүртэлх аж ахуйн нэгж сонгож, саналаа аймгийн Засаг даргад танилцуулан, захирамж гаргуулж байхыг ажлын хэсэг (Ж.Мэнхчулуун)-т, ашигт малтмал худалдан авахаар шалгарсан аж ахуйн нэгжтэй гурван талт гэрээ байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга, аж ахуйн нэгжийн удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.



488010215



Аймгийн Засаг даргын 2018 оны 09 сарын
05-ны өдрийн 13:09 тоот захирамжийн хавсралт

Бичил уурхай эрхлэгчдийн олборлосон ашигт малтмалыг
худалдан авах аж ахуйн нэгжид тавигдах шаардлага
/сонгон шалгаруулалтад бүрдүүлэх материли/

1. Сонгон шалгаруулалтад оролцох тухай хүсэлт албан тоот
2. Аж ахуйн нэгжийн болон тусгай зөвшөөрлийн нотариатаар баталгаажуулсан гэрчилгээний хуулбар
3. Аймгийн Татварын хэлтэст татвар төлөгч болох тухай нотолгоо
4. Сүүлийн 2 жилийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан
5. Татварын болон шүүхийн шийдвэрээр бусдад төлөх өргүй, банкны хугацаа хэтэрсэн зээлгүй болохыг нотлох холбогдох байгууллагуудыг тодорхойлолт
6. Мэргэжилтэй боловсон хүчин /тухайн байгууллагад ажилладгийг нотлох баримт/, машин механизм, техник, хэрэгсэл /тухайн байгууллагад бүртгэлтэй болохыг нотолсон
7. Байгаль орчныг хамгаалах, нехэн сэргээлтийн талаарх ажлын туршлагатай болохыг нотлох баримт бичиг
8. Ашигт малтмал худалдан авах үнийн санал